



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 367

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 206 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Барилга, хот байгуулалтын яамны харьяа Дэд бүтцийн ашиглалтын өмнөх захиргааны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 31,270,541,708.28 (гучин нэгэн тэрбум хоёр зуун далан сая таван зуун дөчин нэгэн мянга долоон зуун найман төгрөг хорин найман мөнгө) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Замын-Үүд Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанд, нийт 18,535,498,517.37 (арван найман тэрбум таван зуун гучин таван сая дөрвөн зуун ерэн найман мянга таван зуун арван долоон төгрөг гучин долоон мөнгө) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Багануур-Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанид тус тус балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагч И.Батнасан, “Багануур-Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Н.Тавинбэх, Дэд бүтцийн ашиглалтын өмнөх захиргааны менежер Г.Мэндсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ,
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТЭСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ,
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЭРДЭНЭБАЯР

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 09 сарын 19-ний өдрийн
367 дугаар тогтоолын хавсралт

**ЗАМЫН-ҮҮДИЙН ДЭД БҮТЦИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ"-ИЙН ХҮРЭЭНД БАРИГДСАН
"ДЭД БҮТЦИЙН АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ЗАХИРГАА"-НЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Барилга, байгууламж (хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ)-ийн нэр	Хөрөнгийн үнэ (ам.доллар)	Хөрөнгийн үнэ (төгрөг)	Шилжүүлэн авч ашиглах, үндсэн хөрөнгөд бүртгэх хуулийн этгээдийн нэр
1	Замын-Үүдийн Чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт байрлах Автозам, гэрэлтүүлэг, явган зам, холбоожуулалтын сувагчлал (багц хөрөнгө оруулалт)	14,835,355.14	31,270,541,708.28	Замын-Үүдийн Чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба
2	Цахилгаан хангамжийн барилга, байгууламж (цахилгааны дэд станц, агаарын шугам, хуваарилах байгууламж, далд кабель зураг төслийн ажлын багц)	8,793,640.15	18,535,498,517.37	"Багануур, зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компани
	Дүн	23,628,995.29	49,806,040,225.65	
		(хорин гурван сая зургаан зуун хорин найман мянга есөн зуун ерэн таван ам.доллар хорин есөн цент)	(дөчин есөн тэрбум найман зуун зургаан сая дөчин мянга хоёр зуун хорин таван төгрөг жаран таван мөнгө)	